

“Цахим сургалтын чанарын хяналтын шалгуур үзвэлтүүдийг тодорхойлох”, “Цахим сургалтын чанарын хяналтын бүтэц, тогтолцоог тодорхойлох” ажил ба судалгааны тайлангууд гарлаа

Цахим Мэдлэг ТББ нь Монгол Улсад цахим сургалтыг нэвтрүүлэх зорилгоор 2007 онд байгуулагдсан бөгөөд 2009 оноос эхлэн цахим сургалтууд (www.mongolcampus.org) явуулж ирлээ. Онгорсон хугацаанд их, дээд сургууль, коллежийн багш, бизнесийн байгууллагын сургалтын менежерүүд нийт 310 хүнийг цахим сургалтыг тоолох ба хэрэгжүүлэх үр чадварт сургаж тогтоосон ба

тогтоогчид нь цахим сургалтыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

21-р зууны боловсролын чиг хандлага, мэдээллийн технологийн үсрэнгүй хөгжил, сурагч оюутнууд, иргэдийн хэзээ ч хаанаас ч суралцах гэсэн хэрэгцээ нь боловсролын байгууллагууд цахим сургалтыг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага болжээ. Цахим сургалтыг хэрэгжүүлэх явцад тулгамдаж буй асуудал нь цахим сургалтыг нэвтрүүлэх хууль эрх зүйн орчин бүрдээгвйгээс анхаарал дэмжлэг, зохицуулалт сул, цахим сургалтын стандарт байхгүйгээс хэрэгжүүлэгч бүр оор оорийн ойлгосныг цахим сургалт хэмээн нэрлэж явуулдаг, цахим сургалтанд чанарын хяналт тавих тогтолцоо бүрдээгвй зэрэг юм.

Дээрх асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулахын тулд Цахим Мэдлэг ТББ-аас “Цахим сургалтын стандартын тосол боловсруулах, чанарын хяналтын тогтолцоог санаачлах” тослийг хамтран ажиллагч Германы олон улсын хөгжлийн хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)-ийн дэмжлэгтэйгээр 2012 оны 9-р сараас 2013 оны 3-р сарыг хүртэл хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Цахим сургалтын чанарын хяналтын тогтолцоог санаачлах гэдэгт 1-рт, чанарын хяналтын шалгуур үзвэлтүүдийг, 2-рт, чанарыг хэн, хэзээ, хэрхэн хянаж баталгаажуулах вйл явцыг тодорхойлохыг ойлгож буй юм. Уг ажлыг эхлүүлэхийн тулд Цахим Мэдлэгээс “Монголд боловсролын стандартыг боловсруулж хэрэглэж буй байдал”, “Цахим сургалтын чанарын хяналтын Open ECB Check ба олон улсын туршлага” судалгаануудыг 2012 оны 9-10-р сард хийж гүйцэтгэсэн нь тослийн дараагийн алхмуудын үндэс суурь болж байна.

Цахим сургалтын чанарын хяналтын шалгуур үзвэлтүүд ба бүтэц, тогтолцоог тодорхойлох энэхүү ажлаар 2012 оны 11-р сард явуулсан онлайн асуулга, 2012 оны 12-р сард зохион байгуулсан “Цахим сургалтын чанарын хяналтын шалгуур үзвэлтүүдийг тодорхойлох нь”, “Цахим сургалтын чанарын хяналтын тогтолцоог санаачлах нь” семинаруудын үр дүнг нэгтгэн гаргалаа. Түүнчлэн Монгол улсад мордогдож буй дээд болон мэргэжлийн боловсролын сургалтын хотолборийг магадлан итгэмжлэх шалгуурууд ба цахим сургалтын Open ECB Check чанарын хяналтын шалгууруудыг хооронд нь

харьцуулан судалсан дүнг танилцуулсан.

Цахим сургалтын чанарын хяналтын тогтолцоог санаачлах ажилд бүх шатны боловсрол, цахим сургалт, чанарын хяналт, стандартын чиглэлээр ажиллаж ирсэн сонирхогч бүхий л талуудыг оролцуулахыг Цахим Мэдлэгээс чармайж байгаа бөгөөд онлайн асуулга, семинараас гарсан үр дүнг сонирхогч, оролцогч талуудад оргон барьж дахин хэлэлцүүлэхэд энэхүү тайлан ихээхэн ач холбогдолтой юм.

- [“Цахим сургалтын чанарын хяналтын шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох” ажил ба судалгааны тайлан](#), Цахим Мэдлэг ТББ, 2013 оны 1-р сар - 4.24 МВ
- [“Цахим сургалтын чанарын хяналтын бүтэц, тогтолцоог тодорхойлох” ажил ба судалгааны тайлан](#), Цахим Мэдлэг ТББ, 2013 оны 4-р сар - 2.42 МВ